

Монголын математикийн олимпиадыг зохион байгуулах удирдамж

2025 оны 09 сарын 12 өдөр

1 Ерөнхий үндэслэл

- 1.1 Монголын математикийн олимпиадыг (цаашид олимпиад гэх) зохион байгуулахад Боловсролын Ерөнхий Газрын даргын 2023 оны 12 сарын 04 өдрийн А/420 тоот тушаалаар баталсан *Улсын олимпиад зохион байгуулах журмыг* баримтална.
- 1.2 Энэхүү удирдамжаар олимпиадыг зохион байгуулах ангилал, шатлал, олимпиадад оролцох эрх олгох, байр эзлүүлэх аргачлал, бодлого сонгох, засах, бодолт хамгаалах болон бусад зохион байгуулалттай холбоотой асуудлуудыг зохицуулна.
- 1.3 Математикийн дэд хорооны үйл ажиллагааг Монголын Математикийн Олимпиадын Олимпиадын Хороо НҮТББ (цаашид хороо гэх) хэрэгжүүлнэ.
- 1.4 Олимпиадын үйл ажиллагаа аливаа төрлийн ялгаварлан гадуурхалт (үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, шашин шүтлэг, хүйсийн чиг баримжаа, бие махбодын чадварт суурилсан гэх мэт), сэтгэл санаа, бие махбодын хүчирхийлэл болон улс төр, шашнаас ангид байна. Олимпиадын үйл ажиллагаанд оролцогчид бусдадаа хүндэтгэлтэй хандана.

2 Зохион байгуулалтын багууд

Зохион байгуулагч Олимпиадын зохион байгуулалтын асуудлыг хариуцаж оролцогчдыг олимпиадад тав тухтай оролцох боломжоор ханган хяналтын багийг удирдаж ажиллана. Мөн тусгайлан өөрөөр заагаагүй бол олимпиад зохион байгуулах санхүүжилтыг хариуцна.

Эрдмийн баг Хороог төлөөлж олимпиадын эрдмийн үйл ажиллагааг хариуцаж бодлогын багийг удирдаж ажиллана. Олимпиадад оролцох эрхийг эрдмийн баг олгоно.

Бодлогын баг Бодлого зохиох, бусдын дэвшүүлсэн бодлогыг хүлээж авах, хянах, сонгохтой холбоотой асуудлууд болон бодлогын нууцлалыг хариуцна. Бодлого засах аргачлалыг боловсруулж эрдмийн багаар батлуулна.

Засалтын баг Батлагдсан бодлого засах аргачлалын дагуу бодолт засах ажил болон засалт хамгаалах ажлыг хариуцна. Засалтын багийг эрдмийн баг эсвэл зохион байгуулагч томилох ба томилогч олимпиадын дүн болон шагналуудыг батална.

Хяналтын баг Эрдмийн баг ба зохион байгуулагчийн зааврын дагуу танхимын бодолтыг дүрмийн дагуу шударга зохион байгуулж оролцогчдын бодолтуудыг засалтын багт хүлээлгэж өгөх ажлыг хариуцна.

Ажиглалтын баг Шаардлагатай тохиолдолд эрдмийн багаас томилох ба зохион байгуулагч ажиглалтын багт олимпиад дүрмийн дагуу шударга явагдаж байгаа эсэхэд хяналт тавих боломж олгох үүрэгтэй.

3 Ангилал

3.1 Олимпиадад төрийн өмчийн болон төрийн өмчийн бус ерөнхий боловсролын сургуулийн (цаашид сургууль гэх) сурагчид болон үндсэн багш, захирал, сургалтын менежер (цаашид багш гэх) нар оролцож болох ба оролцогчид

C, D, E, F, S, T

гэсэн зургаан ангилалд уралдана.

3.2 C ангилалд 5, 6-р ангийн түвшний бодлого тавигдана. Энэ ангилалд 6 болон түүнээс доош ангийн сурагчид оролцож болно.

3.3 D ангилалд 7, 8-р ангийн түвшний бодлого тавигдана. Энэ ангилалд 8 болон түүнээс доош ангийн сурагчид оролцож болно.

3.4 E ангилалд 9, 10-р ангийн түвшний бодлого тавигдана. Энэ ангилалд 10 болон түүнээс доош ангийн сурагчид оролцож болно.

3.5 F ангилалд 11, 12-р ангийн түвшний бодлого тавигдана. Энэ ангилал бүх сурагчдад нээлттэй.

3.6 S ангилалд бага ангийн багш нар оролцож болно.

3.7 T ангилалд багш нар оролцож болно.

4 Шатлал

4.1 Олимпиадыг

I даваа, II давааны I шат, II давааны II шат, III даваа

гэсэн дөрвөн шатлалтай зохион байгуулна.

4.2 I давааг сургуулийн олимпиад гэж нэрлэнэ.

4.3 II давааны I шатыг Улаанбаатар хотод *дүүргийн*, хөдөө орон нутагт *аймгийн* олимпиад гэж нэрлэнэ. Багануур, Багахангай, Налайх дүүргүүд энэ шатлалыг хамтран зохион байгуулна.

4.4 II давааны II шатыг Улаанбаатар хотод *нийслэлийн*, хөдөө орон нутагт *бүсийн* олимпиад гэж нэрлэнэ. Аймгуудыг дараах байдлаар бүсэд хуваана.

Бүс	Аймаг
Баруун	Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд
Говь	Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь
Төв	Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл
Зүүн	Дорноговь, Дорнод, Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий


4.5 III давааг *улсын* олимпиад гэж нэрлэнэ.

4.6 Шатлал бүрд дараах ангиллууд зохион байгуулагдана.

Шатлал	Ангилал
I даваа	C D E F
II давааны I шат	C D E F S T
II давааны II шат	D E F S T
III даваа	E F T

4.7 Оролцогчид шатлал бүрээс дараагийн шатлалын тухайн ангилалдаа оролцох эрхээ авах ба шатлал ахихад ангилал солих боломжгүй. Эрх авсан оролцогч олимпиадад оролцох боломжгүй болсон тохиолдолд нөхөж эрх олгохгүй. Мөн II давааны I шатнаас III даваанд

оролцох эрх авах боломжтой.



4.8 Тухайн шатлалд 0 оноо авсан оролцогч дараагийн шатлалд оролцох боломжгүй.

4.9 Өөрөөр заагаагүй тохиолдолд багийн зохион байгуулалтыг дараах байдлаар хийнэ.

Шатлал	Бодлогын баг	Засалтын баг	Хяналтын баг	Ажиглалтын баг
I даваа	хороо	систем	сургууль	хороо
II даваа I шат	хороо	аймаг/дүүрэг	аймаг/дүүрэг	хороо
II даваа II шат	хороо	бүс/нийслэл	бүс/нийслэл	
III даваа	хороо	хороо	зохион байгуулагч	

5 I даваа

5.1 I даваа буюу *сургуулийн* олимпиадыг C, D, E, F ангиллуудаар сурагчдын дунд зохион байгуулна. Энэ шатлал ангиллын шаардлага хангасан бүх сурагчид нээлттэй.

5.2 Сургуулийн олимпиад зохион байгуулагдахаас 4 долоо хоногийн өмнө олимпиад зохион байгуулах ажлын хэсгийг сургуулийн захирал томилох ба үйл ажиллагаатай холбоотой төсвийг тухайн жилийн төсөвт суулган санхүүжүүлнэ.

5.3 Олимпиадад оролцох багш сурагчдын бүртгэлийн асуудлыг ажлын хэсэг хариуцна.

5.4 Олимпиадыг нөхөх тест хэлбэрээр нэг өдөр зохион байгуулна.

5.5 Бодлогын багийг хороо томилно.

5.6 Засалтыг mmo.mn системээр хийнэ.

5.7 Ядаж 1 оноо авсан сурагчдыг ангилал бүрд нийлбэр оноогоор их оноотойгоос бага оноотой руу жагсаан, дараах байдлаар II давааны I шатанд оролцох эрх олгоно. Оноо тэнцсэн тохиолдолд аль цөөнийг сонгоно. Босго оноог багасгах эсвэл нэг сургуулиас оролцох сурагчийн тоог ихэсгэх замаар зохион байгуулагч оролцогчийн тоог нэмэх боломжтой.

Дүүргийн эрх, жагсаалтаар: Ангилал бүрд дүүргийн шаардлага хангасан сургуулиудын сурагчдын жагсаалтын эхний 50 сурагч тухайн дүүргийн олимпиадад оролцох эрх авна. Шаардлага хангахын тулд сургуулийн олимпиадыг тухайн дүүргийн нэг болон түүнээс дээш сургуультай хамтран зохион байгуулна.

Дүүргийн эрх, сургуулиас: Нэмэлтээр, ангилал бүрд жагсаалтаар эрх аваагүй сурагчдаас сургууль бүрийн эхний 3 сурагч дүүргийн олимпиадад оролцох эрх авна.

Аймгийн эрх, жагсаалтаар: Ангилал бүрд аймгийн сурагчдын жагсаалтын эхний 20 сурагч аймгийн олимпиадад оролцох эрх авна.

Аймгийн эрх, сургуулиас: Нэмэлтээр, ангилал бүрд жагсаалтаар эрх аваагүй сурагчдаас сургууль бүрийн эхний 2 сурагч аймгийн олимпиадад оролцох эрх авна.

5.8 Шагналын асуудлыг ажлын хэсэг шийдвэрлэнэ.

6 II давааны I шат

6.1 II давааны I шат буюу *аймаг/дүүргийн* олимпиадыг C, D, E, F, S, T ангиллуудаар зохион байгуулна.

- 6.2 Бодлогын багийг хороо томилно. Бусад зохион байгуулалтыг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлэн зохион байгуулна.
- 6.3 С, D, S ангилалд 1 өдөр × 4 бодлого/өдөр, E, F, T ангилалд 2 өдөр × 3 бодлого/өдөр тавигдана.
- 6.4 Энэ шатлалд багш нар болон I даваанаас эрх авсан сурагчид оролцоно.

Тухайн дүүрэг эсвэл аймагт I даваа зохион байгуулагдаагүй тохиолдолд боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага оролцох эрхийг шийдвэрлэнэ.

	Жагсаалтаар	Сургуулиас
Аймаг	20	2
Дүүрэг	50	3

Зохион байгуулагч нь босго оноог өөрчлөх замаар оролцогчийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

- 6.5 Ядаж нэг 1 оноо авсан оролцогчдыг ангилал бүрд нийлбэр оноогоор их оноотойгоос бага оноотой руу жагсаан, дараах байдлаар дараагийн шатлалд оролцох эрхийг олгоно. Оноо тэнцсэн тохиолдолд аль цөөнийг сонгоно. Босго оноог өөрчлөх замаар бүсийн олимпиадыг зохион байгуулагч оролцогчийн тоог нэмэх боломжтой.

Хотын эрх, жагсаалтаар: Нийслэлийн оролцогчдын жагсаалтын D, E, F ангилалд **30** оролцогчийг нийслэлийн олимпиадад дүүргүүдийн эхний 30 байрт шалгарсан гурван жилийн дундаж хувиар сонгоно. S, T ангилалд **10** оролцогчийг мөн ижил аргаар сонгоно. Бутархай тоог түүнээс багагүй хамгийн бага бүхэл тоогоор бүхэлчилнэ.

Хотын эрх, дүүргээс: Жагсаалтаар эрх аваагүй оролцогчдоос D, E, F ангилалд дүүргүүдийн эхний **20** байрт шалгарсан сурагчид болон S, T ангилалд эхний **10** байрт шалгарсан багш нар нийслэлийн олимпиадад оролцох эрх авна.

Бүсийн эрх: D, E, F ангилалд аймгуудын эхний **10** байрт шалгарсан сурагчид болон S, T ангилалд эхний **5** байрт шалгарсан багш нар бүсийн олимпиадад оролцох эрх авна.

Улсын эрх: E, F, T ангилалд аймаг, дүүрэг бүрээс тус бүр эхний **2** байрт шалгарсан нийт **6** багш, сурагч улсын олимпиадад оролцох эрх авна. Оноо тэнцсэн оролцогчдыг II давааны II шатны оноогоор жагсаан эрх олгоно.

- 6.6 Шагналын асуудлыг зохион байгуулагч шийдвэрлэнэ.

7 II давааны II шат

- 7.1 II давааны II шат буюу *бүс/нийслэлийн* олимпиадыг D, E, F, S, T ангиллуудаар зохион байгуулна.
- 7.2 Бүсийн олимпиадыг тухайн бүсийн аль нэг аймаг зохион байгуулна.
- 7.3 Бүсийн олимпиадыг зохион байгуулагч аймгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага олимпиад зохион байгуулах ажлын хэсэг ба засалтын багийг томилох ба олимпиадын үйл ажиллагааг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Бүсийн олимпиадад оролцох зардлыг оролцогч аймгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
- 7.4 Хотын олимпиадыг зохион байгуулагчийг болон засалтын багийг нийслэлийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллага томилох ба үйл ажиллагааны зардлыг тухайн жилийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
- 7.5 Энэ шатлалд II давааны I шатнаас эрх авсан багш, сурагчид оролцоно.

Хаана		D	E	F	S	T	Нийт
Баруун бүс	5	10	10	10	5	5	200
Говийн бүс	4	10	10	10	5	5	160
Төвийн бүс	7	10	10	10	5	5	280
Зүүн бүс	5	10	10	10	5	5	200
Нийслэл	7	20	20	20	10	10	670
	1	30	30	30	10	10	
Нийт		350	350	350	180	180	1510

Зохион байгуулагч аймаг нь босго оноог багасгах замаар бүсийн олимпиадад оролцох оролцогчийн тоог нэмэгдүүлэх боломжтой. Мөн зохион байгуулагч аймаг 10 хүртэл хүнтэй нэг баг нэмэлтээр оруулах эрхтэй.

7.6 Аймгаас E, F ангилалд II давааны I шатанд эрх авсан сурагч энэ шатлалд Улаанбаатар хотод оролцож болно. Энэ тохиолдолд нийслэлээс III даваанд оролцох эрхээ авах шаардлагатай.

7.7 II давааны I шатнаас III даваанд оролцох эрх аваагүй оролцогчдыг ангилал тус бүрд нийт оноогоор их оноотойгоос бага оноотой руу жагсаан, III даваанд оролцох нэмэлт эрхийг дараах байдлаар олгоно. Оноо тэнцсэн тохиолдолд аль цөөнийг сонгоно.

Улсын эрх, бүсээс: Бүсийн E, F ангилал тус бүрд дээрх жагсаалтын эхний 2 байрт жагссан сурагч, T ангиллын эхний 1 байрт жагссан багш III даваанд оролцох эрх авна.

Улсын эрх, нийслэлээс: Нийслэлийн E, F ангилал тус бүрд дээрх жагсаалтын эхний 20 байрт жагссан сурагч, T ангилалд эхний 6 байрт жагссан багш III даваанд оролцох эрх авна.

7.8 Шагналын асуудлыг зохион байгуулагч шийдвэрлэнэ.

8 III даваа

8.1 III даваа буюу *улсын* олимпиадыг E, F, T ангиллуудаар зохион байгуулна.

8.2 Улсын олимпиад зохион байгуулах хүсэлтийг хороо хүлээн авч батална.

8.3 Зохион байгуулах ажлын хэсгийг зохион байгуулагч болон хороо хамтран томилно.

8.4 Энэ шатлалд II давааны I шат, II давааны II шатнаас эрх авсан багш, сурагчид оролцоно.

Эрх	Хаана		E	F	T	Нийт
II даваа I шат	Аймаг	21	2	2	2	126
	Дүүрэг	7	2	2	2	42
II даваа II шат	Бүс	4	2	2	1	20
	Нийслэл	1	20	20	6	46
	Нийт		84	84	66	234

Улсын эрх, зохион байгуулагчаас: Зохион байгуулагчийн зүгээс хүсэлт гаргавал 6 хүртэлх хүнтэй нэг баг нэмэлтээр оролцуулж болох ба энэ багт нэмэлт шаардлага тавихгүй.

8.5 E, F ангилалд медалийг дараах байдлаар олгоно.

8.5.1 Алтан медалийн болзлыг 1-ээс 2 сурагч хангахаар хамгийн цөөн алтан медаль өгнө.

8.5.2 Алт, мөнгөн медалийн болзлыг 5-аас 8 сурагч хангахаар хамгийн цөөн мөнгөн медаль өгнө.

8.5.3 Алт, мөнгө, хүрэл медалийн болзлыг 14-өөс 18 сурагч хангахаар хамгийн цөөн хүрэл медаль өгнө.

8.5.4 Дээрх нөхцөлүүдийг бүгдийг хангахаар медаль өгөх боломжгүй бол медалийн хуваарилалтыг хороо шийднэ.

8.6 Т ангилалд медалийг дараах байдлаар олгоно.

8.6.1 Алтан медалийн болзлыг 1-ээс 2 багш хангахаар хамгийн цөөн алтан медаль өгнө.

8.6.2 Алт, мөнгөн медалийн болзлыг 3-аас 4 багш хангахаар хамгийн цөөн мөнгөн медаль өгнө.

8.6.3 Алт, мөнгө, хүрэл медалийн болзлыг 6-аас 8 багш хангахаар хамгийн цөөн хүрэл медаль өгнө.

8.6.4 Дээрх нөхцөлүүдийг бүгдийг хангахаар медаль өгөх боломжгүй бол медалийн хуваарилалтыг хороо шийднэ.

8.7 Зохион байгуулагчийн зүгээс нэмэлт шагналыг санаачлах боломжтой.

9 Бодлого дэвшүүлэх

9.1 Олимпиадад бодлого дэвшүүлэх эрх ашиг сонирхлын зөрчилгүй бүх хүнд нээлттэй.

9.2 Олимпиадад зөвхөн өөрийн зохиосон шинэ бодлогыг дэвшүүлэх ба дэвшүүлсэн бодлогын нууцлалыг чандлан хадгална. Тухайлбал, тухайн бодлого болон түүнтэй төстэй бодлогыг өөр олимпиад уралдаанд дэвшүүлэхгүй.

9.3 Бодлого дэвшүүлэхдээ дараах мэдээллийг бодлогын багийн ахлагчид олимпиад болохоос 1 сарын өмнө өгнө.

9.3.1 Овог, нэр

9.3.2 Харьяаллын албан байгууллага, сургууль болон албан тушаал

9.3.3 Ашиг сонирхлын зөрчлийн мэдээлэл (хичээл ордог эсвэл ойрын хамаатан оролцогчийн мэдээлэл)

9.3.4 Бодлого

9.3.5 Бодолт

9.3.6 Бодлогын тухай мэдээлэл (хүндрэл, санааны эх сурвалж гэх мэт)

9.4 Бодлого сонголтыг бодлогын баг хариуцна. Тухайлбал, бодлогыг дэвшүүлэх эсэх болон аль шатлалын аль ангилалд эсвэл сонгон шалгаруулах сорил, олон улсын олимпиадууд дэвшүүлэхийг бодлогын баг шийднэ.

Олон Улсын Математикийн Олимпиадад оролцох багийг сонгох удирдамж

1 Ерөнхий зүйл

- 1.1 Олон Улсын Математикийн Олимпиадад (ИМО) Монгол Улсыг төлөөлж, ИМО-ын дүрмийн дагуу, зургаан (6) гишүүнтэй баг оролцоно. Энэ багийг *албан ёсны баг* гэнэ.
- 1.2 Албан ёсны багт зөвхөн ИМО-ийн дүрмийн дагуу Монгол Улсыг төлөөлөн ИМО-д оролцох эрх бүхий сурагч багтаж болно. Тухайлбал ИМО зохион байгуулагдах жилийн 7 сарын 1 өдөр 20 нас хүрээгүй, өмнөх оны 12 сарын 1 өдөр ерөнхий боловсролын сургуульд суралцаж байх хэрэгтэй.
- 1.3 Албан ёсны багийг *удирдагч, дэд удирдагч* нар ахлан авч явах бөгөөд удирдагч, дэд удирдагчийг хороо томилно.
- 1.4 Албан ёсны багийг ажиглагч даган явж болох ба ажиглагчийг хороо сонгоно.

2 Сонгон шалгаруулах сорил

- 2.1 Сонгон шалгаруулах сорилд ИМО дүрмийн дагуу албан ёсны багт багтах боломжтой бөгөөд олимпиадын III давааны F ангилалд оролцох эрх авсан сурагчид оролцоно.
- 2.2 Сорилыг хоёр өдрийн турш өдөрт тус бүр 7 оноотой гурван бодлого бодох хэлбэрээр зохион байгуулна.
- 2.3 Олимпиадын III давааны F ангиллыг сонгон шалгаруулах сорилд тооцно.
- 2.4 Дээрхийг оруулаад сорилыг гурван удаа зохион байгуулна.

3 Албан ёсны багийн гишүүдийг сонгох

- 3.1 Сонгон шалгаруулах сорилуудын оноонуудын нийлбэрийг *нийт* оноо гэж нэрлэнэ. Аль нэг сорилд оролцоогүй бол тухайн сорилын оноог тэг (0) гэж тооцно.
- 3.2 Сурагчдыг нийт онооны ихээс бага руу жагсаана. Ижил оноотой сурагчдыг нэрсийн цагаан толгойн дарааллын дагуу жагсаана.
- 3.3 Эхний зургаан байрт шалгарсан сурагчдын оноо бусад сурагчдынхаас эрс их бол энэ сурагчид албан ёсны багийг бүрдүүлнэ.
- 3.4 Оноо тэнцэлтийн улмаас албан ёсны баг бүрдээгүй тохиолдолд оноо тэнцсэн сурагчдын дунд нэмэлт сорил зохион байгуулж албан ёсын багийг тодруулна.
- 3.5 Дээрх жагсаалтын дарааллаар албан ёсны багийн гишүүдийн дарааллыг тогтооно.
- 3.6 Албан ёсны багт шалгарсан сурагч олимпиадад оролцох боломжгүй болсон тохиолдолд эрх шилжихгүй ба нэмэлт сонгон шалгаруулалт явуулахгүй.

Европын Охидын Математикийн Олимпиадад оролцох багийг сонгох удирдамж

1 Ерөнхий зүйл

- 1.1 Европын Охидын Математикийн Олимпиад (EGMO)-д Монгол Улсыг төлөөлж, EGMO-ийн дүрмийн дагуу, дөрвөн (4) эмэгтэй гишүүнтэй баг оролцоно. Энэ багийг *албан ёсны баг* гэнэ.
- 1.2 Албан ёсны багт зөвхөн EGMO дүрмийн дагуу Монгол Улсыг төлөөлөн EGMO-д оролцох эрх бүхий сурагч багтаж болно.
- 1.3 Албан ёсны багийг *удирдагч, дэд удирдагч* нар ахлан авч явах бөгөөд удирдагч, дэд удирдагчийг хороо томилно.
- 1.4 Албан ёсны багийг ажиглагч даган явж болох ба ажиглагчийг хороо сонгоно.

2 Сонгон шалгаруулах сорил

- 2.1 Сонгон шалгаруулах сорилд EGMO дүрмийн дагуу албан ёсны багт орох боломжтой бөгөөд олимпиадын II давааны I шатанд E эсвэл F ангилалд оролцож ядаж нэг оноо авсан эмэгтэй сурагчид оролцож болно.
- 2.2 Сорилыг хоёр өдрийн турш өдөрт тус бүр 7 оноотой гурван бодлого бодох хэлбэрээр зохион байгуулна.
- 2.3 Сорилыг хоёр удаа зохион байгуулна.

3 Албан ёсны багийн гишүүдийг сонгох

- 3.1 Сонгон шалгаруулах сорилуудын оноонуудын нийлбэрийг *нийт* оноо гэж нэрлэнэ. Аль нэг сорилд оролцоогүй бол тухайн сорилын оноог тэг (0) гэж тооцно.
- 3.2 Сурагчдыг нийт онооны ихээс бага руу жагсаана. Ижил оноотой сурагчдыг нэрсийн цагаан толгойн дарааллын дагуу жагсаана.
- 3.3 Эхний дөрвөн байрт шалгарсан сурагчдын оноо бусад сурагчдынхаас эрс их бол энэ сурагчид албан ёсны багийг бүрдүүлнэ.
- 3.4 Оноо тэнцэлтийн улмаас албан ёсны баг бүрдээгүй тохиолдолд оноо тэнцсэн сурагчдын дунд нэмэлт сорил зохион байгуулж албан ёсын багийг тодруулна.
- 3.5 Дээрх жагсаалтын дарааллаар албан ёсны багийн гишүүдийн дарааллыг тогтооно.
- 3.6 Албан ёсны багт шалгарсан сурагч олимпиадад оролцох боломжгүй болсон тохиолдолд эрх шилжихгүй ба нэмэлт сонгон шалгаруулалт явуулахгүй.

Ү.ОТГОНБАЯР

Олимпиад болон сонгон шалгаруулах сорилд оролцох ерөнхий удирдамж

- 1.1 Оролцогч бодолтын цаг эхлэхээс 20 минутын өмнө танхимд суудлаа эзэлсэн байна. Бодлого задарснаас хойш оруулахгүй.
- 1.2 Оролцогч бодлогоо бие даан бодох ба бусдаас аливаа хэлбэрийн тусламж авахыг хориглоно.
- 1.3 Оролцогч бодолтод зөвхөн үзэг, бал, шугам, гортиг, баллуур гэх мэт бичих болон зурах хэрэгсэл ашиглаж болно. Компьютер, гар утас, таблет, тооны машин болон бусад цахим төхөөрөмж болон холбооны хэрэгсэл ашиглахыг хориглоно.
- 1.4 Оролцогч үнэр, чимээ багатай хөнгөн идэх, уух зүйлс бодолтын танхимд авч орж болох ба бодолтын үеэр хэрэглэж болно.
- 1.5 Оролцогч хянагчийн зүй ёсны шаардлагыг биелүүлнэ.
- 1.6 Оролцогч бодолтын цаг эхэллээ гэж зарлах хүртэл бодлого харахгүй ба бодолтын цаг дууслаа гэж зарласны дараа бодолтын цаасанд нэмэлт өөрчлөлт оруулахгүй.
- 1.7 Оролцогч бодолт дууссан бол бодолтын цаасаа хянагчид тоолон хүлээлгэж өгнө.

Ү.ОТГОНБАЯР

2025-2026 оны хичээлийн жилийн удирдамж

1 Гүйцэтгэх зөвлөлийн гишүүд ба ажил үүрэг

Дарга	Эрдмийн багийн ахлагч	Ү. Отгонбаяр
Нарийн бичгийн дарга		С. Цогзолмаа
Гишүүд	Ахлах ангилалын бодлогын багийн ахлагч	Г. Баярмагнай
	Дунд ангилалын бодлогын багийн ахлагч	Б. Батбаясгалан
	Засалтын багийн ахлагч	Т. Хулан
	IMO багийн ахлагч	Ү. Отгонбаяр
	IMO багийн дэд ахлагч	У. Батзориг
	EGMO багийн ахлагч	Т. Хулан
	EGMO багийн дэд ахлагч	С. Цогзолмаа
	Мэдээллийн технологийн багийн ахлагч	Б. Батбаясгалан
	Төслийн удирдагч	Г. Номин

2 Үйл ажиллагааны төлөвлөгөө

Үйл ажиллагаа	Хаана	Хэзээ	Ангилал
ММО I даваа	Сургууль	2025/10/24	CDEF
ММО II даваа I шат	Аймаг/дүүрэг	2025/12/13-14	CDEFST
ММО II даваа II шат	Бүс/нийслэл	2026/02/28-03/01	DEFST
ММО III даваа	Баянхонгор	2026/03/28-04/02	EF T
EGMO сонгон шалгаруулах сорил 1	Улаанбаатар	2026/01/24-25	EF
EGMO сонгон шалгаруулах сорил 2	Улаанбаатар	2026/02/07-08	EF
Европын Охидын Математикийн Олимпиад	Франц	2026/04/09-15	F
IMO сонгон шалгаруулах сорил 1	Улаанбаатар	2025/03/14-15	F
IMO сонгон шалгаруулах сорил 3	Улаанбаатар	2025/04/25-26	F
Олон Улсын Математикийн Олимпиад	Хятад	2025/07/10-20	F
Ираны Геометрийн Олимпиад	УБ 1-р сургууль	2025/10/17	DEF T
Ази-Номхон Далайн Математикийн Олимпиад	УБ 11-р сургууль	2025/03/10	F
Олон Улсын Математикийн Зуны Сургалт	Хятад	TVA	F

Олон улсын олимпиадын бэлтгэлийг E, F ангилалын сурагчдын дунд өвлийн 2025/02/02-2025/03/26 ба хаврын 2025/04/20-2025/06/16 гэсэн хоёр шаттай зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энд төлөвлөгдсөнөөс бусад үйл ажиллагаанд хороо оролцохгүй.

3 Нийслэлийн олимпиадад дүүргүүдээс жагсаалтаар эрх авах оролцогчдын тоо

2025-2026 оны хичээлийн жилд жагсаалтын эрхийг дараах байдлаар олгоно.

	D	E	F	S	T
Багануур, Багахангай, Налайх	1	0	0	0	0
Баянгол	4	4	6	1	1
Баянзүрх	7	3	1	2	1
Сонгинохайрхан	0	0	0	0	1
Сүхбаатар	17	20	21	4	7
Хан-Уул	3	4	4	3	2
Чингэлтэй	1	1	0	2	0
Нийт	33	32	32	12	12